



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 6,100,000.00 (зургаан сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Наангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НААНГЭРЭЛ

132001305

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн  
112 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас одоох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг )
1	"Киа карнивал" 07-05 УНУ (арал-KNAMG817BE6552459)	2013-12-10	195571	6,100,000.00	2,000,000.00
	Нийт дүн			6,100,000.00	2,000,000.00